

IV. ТҮҮХЭН ТЭМДЭГЛЭЛ, ДОМОГ, ЯРИА, ШҮҮМЖ

МАРШАЛ ЧОЙБАЛСАНГИЙН ЗОХИОСОН ДУУНЫ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХЭД

Д.Баасанжав
Зохиолч, яруу найрагч

Өгүүллийн товч утга: XX зууны Монголын улс төрийн зүтгэлтэн Х.Чойбалсан өөрийнхөө дотно бүсгүйчүүдэд зориулж дуу зохиож байсныг тодруулан судалжээ.

Түлхүүр үг: Цэрмаа, Бортолгой, Дэвээ, Гүндэгмаа.

Энэ дууг бидний үе тэнгийнхэн болоод эцэг эх ах эгч нарын минь дуулах дуртай “Эрэлхэг Монголын чимэг болон хайрлагдсан Чойбалсан” гэж дуулуулж явсан, Өрлөг жанжин маршал Хорлоогийн Чойбалсан гуай зохиосон гэдэг” домог яриа бий.

Хууч дэлгэхэд, Хувьсгалын дараа хүрээ хөдөөгүй алдар нэр нь цуурайтсан зүс царай сайтай сэргэлэн, тухайн үедээ өндөр боловсрол олж Эрхүүд сурч байсан залуу жанжин Чойбалсанг тэр цагийн хүрээ хорооны ганган хүүхнүүд ихэд шохоорхон Ши янгуу үзвэр үйлчилгээ хүн олон цугларсан газар харах гэж гүйлдэж байсан гэдэг.

Хувьсгалаас урьд Санбэйсийн хүрээнээс нийслэл хүрээнд ирээд хүн танихгүй, газар мэдэхгүй үүрэгчин хийж явах үед нь танилцсан баян панзчин Норовын охин өөрөөс нь хэдэн насаар эгчмэд Цэрмаа гэгч бүсгүй Чойбалсанд их тус болсон аж.

Эрхүүд суралцах үед ээжтэйгээ уулзах гэж нутаг явах зэрэг болон өмсөж зүүхэд нь хүртэл тус болж байсан алтан шүдэт Цэрмаагийн тухай хүрээнийхэн их ярьдаг байжээ. Урд Туулын Улахын булангийн Цэнд, Цэрмаа гэдэг хоёр сайхан бүсгүй байсны нэг нь гэж ярьдаг.

Цэрмаа Чойбалсанг Хиагтад ид хувьсгалын ажлаар явж байх үед нь өвчний учир нас баржээ.

Ардын хувьсгал байгуулагдсаны дараагийн жилүүдэд Чойбалсангийн түшиг тулгуур суларч амьдрал уруудсан нэг үе бий. Бодоо буруутгагдаж түүний хамсаатан гэж нүд үзүүрлэгдэх болжээ.

Чойбалсан Цэрмаатайгаа уулзаж чадаагүй зэргээс болж гундуухан явах үедээ Богдын дотоод ордны оёдолчин байсан Бортолгой хэмээх Зэвгээ гэдэг бүсгүйтэй танилцсан гэдэг.

Бортолгой нь нэлээд эд юмтай бурхан тахил их эй айлын охин (Ах Жамбал нь Богдын Донир байсан) үйлэнд шаггүй уран алиа хошин, ил шударга үгтэй, их шүтлэгтэй энэ бүсгүйтэй Чойбалсан танилцсан үедээ тэднийд орж суусан гэдэг.

Бортолгой нь өмссөн зүүсэн, зүс царай нуруу туруугаараа хэнд ч гологдохгүй хүрээндээ дээгүүрт ордог гангачуудын нэг нь байжээ. Чойбалсан тэр үед их ажилтай байсан агаад хойшоо ажил сургуулиар явсан үеэр нь хосын тухай хошин шог дуу хүртэл гарч байсан гэдэг.

Богдын ордонд элэгтэй

Бортолгой нь алиахандаа

Бошигийг халах залуу жанжин нь

Бурхан үгүй нь хөөрхий дөө гэж дуу гаргаж дуулж байжээ.

Тэрнээс хойш оросод дуудагдаж явахдаа Чойбалсан

Засгийн газраас зарагдаад явсан

Жанжин миний биеэ хө

Залуухан зантай Бортолгой минь

Зангаа битгий хувиргаарай гэж дуулж явсны дараа учир битүүлгээр нэлээд удсаны дараа хойноос эргэж ирэхдээ (Хоёрдугаар хувилбар)

Засгийн газраас томилогдоод ирсэн

Жанжин миний биеэ хө

Залуухан зантай Бортолгой минь

Зангаа юундаа хувиргааа гэж эв хавгүйхэн хоолойгоор дуулж нулимс унагаж суусан гэж ярьдаг.

Чойбалсанг Ардын хувьсгалын дараахан үеэс эхлэн Бодоогийн хамсаатан барууны үзэлтэй Бортолгой болоод Богдын ордныхонтой холбоотой гэж зүүнийхэн Бошигийг халах залуучууд, шүүмжилж Лхүмбийн хэрэгт холбож байснаас Бортолгой Чойбалсангаас хөндийрсөн болов уу гэж бодогдоод байдаг. Хэдийгээр Бортолгой Чойбалсангаас хөндийрсөн ч гэсэн тэр хоёр бие биедээ хайртай уулзаж учирдаг, сэтгэл санааны хүнлэг ёсны тус дэм өгсөөр ирсэн байдаг ажээ. Чойбалсан хэсэг хугацаанд хань ижилгүй явснаа жүжигчин Дэвээ гэдэг хүүхэнтэй танилцаж суух болж, Их тэнгэрийн аманд ганц ширхэг хар хялгас үгүй цагаан эсгий бүрээстэй мөөртэй гоё гэр бариулж Дэвээтэй дэр нийлж хэд хоног найрласан гэдэг. Дэвээг жаахан ааш муутай байсан гэдэг бөгөөд нэг өдөр Чойбалсанд уурлаж:

Хаягдсан хүүхэндээ

Тэрэг унуулдаг хэрнээ

Ханилсан намайг

Ханзархай гуталтай явуулж байхаасаа чи ичихгүй байна уу гэж комиссаруудынх нь дэргэд загнасан гэдэг. Дэвээгийн анхны нөхөр хилсдэж шийтгүүлсэн хүн. Дэвээ намынхаа батлахыг сэргээлгэж төрийн ажилд хушуу дүрдэг гэсэн хов яриа дуулсан Бортолгой нэг өдөр тэгэхээс тэгэх гэсэн шиг фордтой давхиж ирээд халамцуухан Дэвээг загнаж үс толгойдоо хүрэлцэж Маршалд, "Чи төр тэргүүлэх санаатай юм бол төрх муутай эхнэр шүү юмаа төрхөмд нь буцаа" гэж хэлсэн гэдэг. Сүүлдээ Маршал ч Дэвээтэй таарч тохирохоо больж салж Бортолгойн хэлж зөвлөснөөр төрийн ажилд хушуу дүрээд байдаггүй төлөв түвшин Гүндэгмааг авч сууснаар хувийн амьдрал нь сайжирч архи ч уухаа больсон байна. Тэр үеийн залуу хувьсгалчдын моод болж байсан Орос авхай харь бүсгүй аваагүйг нь бодоход Чойбалсан гуай ч тэр Бортолгой ч тэр Монголоо гэсэн холын бодолтой байсны илрэл гэлтэй. Гэтэл Бортолгой Чойбалсангаас салаад сүүлд нь Дуламдахан гэдэг Төвд хүнтэй суусан хэрнээ тэр төвд нөхөр нь баривчилгаанд өртөөгүй гэдэг. Бортолгойг өвчтэй байхад Чойбалсан гуай Эрхүүгээс эмч авчруулж эмчлүүлж, нас барахад нь ажил явдалд нь оролцож байсан зэргийг бодоход Чойбалсан гуай ч Бортолгой гуай ч гэсэн аль аль нь салъя гэж салаагүй салаа үйлийн эрхээр салсан юм уу даа гэж бодохоор байгаа юм.

Чойбалсангийн өөрөө зохиосон гэгдэх Сонгинохайрхан дуунд юу гэж өгүүлснийг үзье.

1. Баруун уулыг саравчлаад харахаар

Барцад ихтэй ч Сонгинохайрхан уулаа хө

Байн байн эрэгцүүлээд бодохлоор нь

Барин тавин үйлтэйхэн хорвоо ёо хө гэсэн бадаг бий.

Анхны 17-гийн хэргээр ихэнхийг нь Сонгино хайрханы ард буудахад Чойбалсан өөрөө согтуу байж удирдсан гэдэг үг бий. Энэ хэрэгтээ ихэд гэмшсэнээс энэ бадаг гарсан нь эргэлзээгүй гэж үзэж болмоор санагдсан.

2. Зүүнтэйх уулыг зүглээд харахад

Зүрхэнд ойрхон Баянзүрх уулаа хө

Зүйл зүйлээр зүйрлээд бодохоор

Зүрх сэтгэл минь үймрээд горьгүй яа хө гэж бадагласныг бодоход тэр үеийн алдаа завхарлыг мэдсэн, мэддэг хэрнээ өөрөөсөө хэтэрсэн дарамт шахалт хүнд нөхцөлд яаж ийгээд цаг хожиж Монгол улсаа тусгаар улс болгон авч яаж үлдэх вэ гэж өдрийн бодол шөнийн зүүдэндээ зовсных гэж үзэж болох юм.

**3. Туулын гүүрээр нь давхиад гарахад
Тунгалаг ус нь туналзаад байна даа хө
Тун чиг дөлгөөн Гүндэгмаатайгаа**

Тухлан суух ч завгүй яа хө гэж дуулсан нь тэр үеийн байдал 1939 оны Халхын голын дайны үе, 1945 оны чөлөөлөх дайн, дайны дараачийн хүнд үед Монголыг өөрийн харъяат гэж улайран зүтгэж ирсэн Хятадын харгис далд санаа цухалзаж байсан төвөгтэй үед улс орноо бие даасан тусгаар тогтносон Монгол Улсаа авч гарсан нь Чойбалсангийн мөнхийн гавъяа гэлтэй.

Ийм улс төрийн хүнд нөхцөлд
Тун ч дөлгөөхөн Гүндэгмаатайгаа
Тухлан суух ч завгүй байсан нь үнэн

Миний бие Чойбалсангийн алдаа завхарлыг зөвтгөх гэсэн санаа өчүүхэн ч үгүй, хойшид залуу эрдэмтэн дүү нар энэ талаар судлах нь зүйн хэрэг. Би зөвхөн өөрөө зохиосон гэгдэх дууных нь шүлэгээс нь өөрийн бодлоо хэлсэн билээ.

Тайлбар:

1. Дуламдахан хэмээх түвэд хүнтэй суусан Бортолгойнхтой айл ногоон нуурын өмнө хятадын 7 нэртэй гудамжинд байсан Ичинхорлоо гэдэг авгай амьд сэрүүнийг нь дуулаад 1959 онд хэд хэд очиж уулзах гэж ядаад сүүлд нь арай гэж уулзаж ярилцаар танил болоход зан ааш сайтай тэр үеийн хүрээ хүүхнүүд харчуудын тухай нэр усаар удам судраар нь ярьж олон уулзахад төвөгшөөж үзээгүй байна. Энэ авгай Бортолгойн илтгэлтэй зарц шивэгчин нь шахуу явжээ. Алтан шүдтэй Цэрмаа гэдэг бүсгүйн тухай Бортолгой нэг удаа ярьсан гэдэг. Тэднийд Чойбалсан гуай хааяахан архи, бэлэгтэй ирдэг байжээ.

Бортолгой ил шударга үгтэй их тусч хүнсэн, үе үе хүрээний дуучид ирж наргина, өөрөө шударга хөгжим муугүй тоглоно. Архи нэлээд уух боловч намба алдана гэж үгүй гэж хуучилж билээ.

2. 1990-ээд оны эхээр "Дээдсийн амьдрал" сонинд Э.Мөнхбүрэн гэдэг хүний бичсэн "Эрэлхэг Монголын чимэг болон хайрлагдсан Маршалын чимэг болсон хүүхнүүд" нэртэй нийтлэл гарсан.

3. Сайн ноён ханы гурван үеийн дархан номхон сайн ханы дархан Цэмбэл, түүний хүү Төгс-Очир Сайн ноён ханы дархан Сангижанцан, түүний хүү Сайн ноён хан Намнансүрэнгийн дархан Цэдэнсамба гэдэг гурван үеийн дархны сүүлчийнх Цэдэнсамба 1939 оны үед Улаанбаатарт ирж хүнд дарх хийж байхад нь Маршалын хуучин авгай Бортолгой Сайн ноён ханы гурван үеийн дархан ирснийг дуулж сурч ирээд мөнгөн заяа үзүүлж өрөөснийг нь алдчихлаа хийж өгөөч гэснийг нь гараа гарган хийж өгчээ. Бортолгой учиргүй баярлаж гэртээ урихад нь тэднийд очвол айлд биш тахилын гэрт орох шиг санагдсан гэнэ. Гэр дүүрэн бурхан тахил болсон айл байсан гэж ярьсныг түүний хүү Сайн ноён Намнансүрэн хөдөлгөөний тэргүүн Ц.Лхагвадорж 1998 онд ярьж билээ.

Abstract: This article demonstrates that renowned Mongolian politician of the XX century Kh. Choibalsan composed songs for his intimate women.